



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 03 дугаар сарын 23 өдөр Дугаар 07

Хэрлэн сум

VII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 07 дугаар хуралдаан 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 76,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн хэмжээнд цаг агаарын нөхцөл байдал, цасны зузаан, ирэх сарууд цаг агаарын урьдчилсан төлөв байдлын мэдээлэл танилцуулах,

Ус цаг уур орчны шинжилгээний төв

2.Баян-Уул суманд эрэн хайх ажиллагаа явуулсан талаарх мэдээлэл танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3.Аймгийн хэмжээнд хэмжээний цас орсонтой холбогдуулан авто замын нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Авто тээврийн төв

4.Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 оны аймгийн төсөвт хөрөнгө тусгах талаар хэлэлцэх,


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга,
Онцгой комиссын гишүүн Г.Гарамхишиг-т:

1.1.Дорнод аймгийн нутгаар цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай дүгнэлтийг 7 хоног тутамд гаргаж танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
“Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын захирал,
Онцгой комиссын гишүүн Ч.Ганбат нарт:

1.2.Их хэмжээний цас орж гамшигт үзэгдлийн нөхцөл байдалд хүрсэнтэй холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Баян-Уул суманд аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаар ахлуулсан ажлын хэсгийг томилж ажиллуулах,

/  / М.Бадамсүрэн
/  / х/ч Б.Цогтбаяр

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
“Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын захирал,
Онцгой комиссын гишүүн Ч.Ганбат,
Хилийн дугаар ангийн захирагч, хурандаа Б.Батболд,
Баян-Уул, Дашбалбар сумын Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

1.3.Баян-Уул, Дашбалбар сумдад цас их орж гамшигт үзэгдлийн нөхцөл байдалд хүрсэнтэй холбогдуулан малын сэг зэм цэвэрлэх, хариу арга хэмжээ авах ажилд Баян-Уул суманд Гал түймэр унтраах, аврах 53 дугаар ангиас 10 албан хаагч, “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-аас 10 албан хаагч, Хилийн 0275 дугаар ангиас 10 албан хаагч, Дашбалбар сумаас 10 иргэнийг дайчлан ажиллуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.4.Их хэмжээний цас орж гамшигт үзэгдлийн нөхцөл байдалд хүрсэнтэй холбогдуулан Баян-Уул, Дашбалбар сумдад хариу арга хэмжээ авах ажилд дайчлагдан ажиллах албан хаагч, иргэдэд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа зааварчилгаа өгч ажиллах,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

1.5.Их хэмжээний цас орж гамшигт үзэгдлийн нөхцөл байдалд хүрсэнтэй холбогдуулан Баян-Уул суманд томилогдон ажиллах ажлын хэсэг, Баян-Уул, Дашбалбар сумдын цасанд дарагдсан айл өрхийн мал, хашаа, хороог чөлөөлөх ажилд дайчлагдан ажиллах 50 хүний 2 хоногийн томилолтын зардал 6,400,000 төгрөг, шатахууны зардал 521,100 төгрөг, Баяндун сумаас Баян-Уул сум руу 30тн өвс тээвэрлэх зардалд 3,000,000 төгрөг, Улсын нөөцөөс Дашбалбар сумын Онцгой комисст олгох 5тн тэжээл тээвэрлэх шатахууны зардал 650,000 төгрөг бүхий нийт 10.571.100 /арван сая таван зуун далан нэгэн мянга нэг зуун төгрөг/-ийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж Засаг даргын нөөцийн сангаас гаргах талаар танилцуулах,

Хоёр.Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

2.1.“Цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төсөлтэй хамтран гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй болзолт уралдаанд хамтарч ажиллах гэрээ байгуулах талаар аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад эрх олгох,

2.2.Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын дунд зохион байгуулах болзолт уралдаанд идэвхитэй оролцсон 3 сумыг шалгаруулж шагнахад гарах зардал 18,000,000 төгрөгийг 2024 оны аймгийн төсөвт тусгахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА М.БАДАМСҮРЭН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ Б.ЦОГТБАЯР

